



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах
тухай


Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 260 дугаар зүйлийн 260.1.4 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 7.4, 7.4.1 дэх заалт, 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 7.4 дэх заалт, 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.9 дэх заалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн шинэтгэлийн 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөр”-ийг нэгдүгээр, “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг харьяа алба, газар, хэлтэс, хорих анги, байгууллага, салбар нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, хөтөлбөрийн арга хэмжээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган үр дүнг тооцож, гүйцэтгэлийг ханган ажиллахыг Захиргааны удирдлагын газар /хурандаа С.Батбямба/-т даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА



Д.ЗАГДЖАВ

1501011208

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 1/14 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР
(2021-2024 он)**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар эрх зүйн орчинг боловсронгуй болгох, салбарын хэмжээнд хууль тогтоомжийн хэрэглээний соёлыг бэхжүүлэх үр дүнг бий болгоход оршино.

1.2. Эрх зүйн үндэслэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн шинэтгэлийн дунд хугацааны хөтөлбөр нь /Цаашид “хөтөлбөр” гэх/ дараах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулагдана.

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хууль тогтоомжийн тухай хууль;
- Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг;
- “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”;

1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төрийн албаны тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан нийтлэг зарчмаас гадна дараах зарчмыг баримтална.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн давхардал, хийдлийг арилгахад чиглэгдсэн байх;

- Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлтэй уялдсан байх;

- Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээнүүд нь хэрэгжихүйц бодитой байх;
- Алба хаагчдын эрх зүйн байдлыг дээшлүүлэх бодлого, чиглэлийг агуулсан байх;
- Хөтөлбөрийн хүрээнд батлагдах эрх зүйн актууд нь хүртээмжтэй чанартай байх;
- Хууль тогтоомжийн хоорондын уялдаа холбоог хангаж, шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг нэг мөр хангахуйц байх;

1.4. Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” нь 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр шинэчлэн батлагдсанаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, хорих ангийн төрөл, дэглэм, алба хаагчийн эрх зүйн болон аюулгүй байдал зэрэг зарчмын болон ялын бодлогын өөрчлөлт орсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан 4, Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан 3, Засгийн газрын тогтоолоор батлагдсан 35, Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор батлагдсан 9, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан 52, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын тушаалаар батлагдсан 2, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан 108, нийт 213 дүрэм, журам, эрх зүйн актыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 7.4-т “Хууль сахиулах салбарын эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжих, ажиллах нөхцөлийг сайжруулах, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ”, 7.4.1-т “Салбарын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлнэ” гэж тус тус заасан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, агуулга, арга зүйг боловсронгуй болгох, түүнчлэн салбарын хэмжээнд хууль хэрэглээ соёлыг бэхжүүлэх цогц тогтолцоог бүрдүүлэх шаардлагад тулгуурлан энэхүү хөтөлбөрийг боловсрууллаа.

Хоёр. Хөтөлбөрийн стратеги зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

1 дүгээр зорилт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэх;

2 дугаар зорилт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлыг

тогтмолжуулах;

3 дугаар зорилт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бодит хэрэгцээ, шаардлагад тулгуурлан эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх;

4 дүгээр зорилт: Салбарын хэмжээнд үйлчилж буй эрх зүйн актуудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хууль тогтоомжийг чиглэл тус бүрээр төрөлжүүлэн нэгтгэх, нэгтгэн найруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

5 дугаар зорилт: Салбарын хэмжээнд хууль хэрэглээний соёлыг бэхжүүлэх сургалт, суртчилгаа, нөлөөллийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах;

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

3.1. Хөтөлбөрийг 2021-2024 онд 4 жилийн хугацаанд 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

3.1.1. **I үе шат:** 2021-2022 онд байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, давхардал хийдлийг арилгаж, шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулна.

3.1.2. **II үе шат:** Салбарын хэмжээнд хууль хэрэглээ соёлыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэх **нэгдүгээр дүгээр зорилтын хүрээнд:**

- Гадаадын зарим улс орны ижил чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг өөрийн орны хууль тогтоомжтой харьцуулан судлах /2021-2024 он/;

- Дотоод хэргийн их сургуультай хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэрэгцээ шаардлагад тулгуурлан захиалгат судалгааны ажлыг гүйцэтгүүлэх /2021-2024 он/;

- Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллага, их дээд сургуулиудтай хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажлыг хэрэгжүүлэх /2022-2023 он/;

- Хууль зүйн салбарын тэргүүлэх зэргийн эрдэмтэн, судлаачидтай хамтран эрүүгийн ялын бодлого, эрүү, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох суурь болон хавсарга судалгааны ажлыг гүйцэтгэх /2021-2022 он/;

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг

боловсронгуй болгох чиглэлээр судалгааны ажлыг өргөжүүлэх/2022-2023/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх арга замыг тодорхойлох хавсарга судалгааны ажлыг хэрэгжүүлэх; /2021-2022 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүргийн онцлогт тулгуурлан байгууллагын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсруулан үйл ажиллагаанд нэвтрүүлэх /2022-2023 он/;

- Эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах замаар байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд тулгамдаж буй сорилт, бэрхшээлийг тодорхойлох /2021-2024 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын чиглэлээр доктор, магистрын түвшний судалгааны ажлын сэдэв, чиглэлийг тодорхойлох; /2021-2022 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг практик үйл ажиллагаанд эргэлтэд оруулах тодорхой ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх; /2022-2024 он/;

4.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлыг тогтмолжуулах **хоёрдугаар зорилтын хүрээнд:**

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, харьяа салбар нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлыг тусган хэрэгжилтийг хангах /2021-2024 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм, журмыг шинээр боловсруулах, хэрэгцээ шаардлагыг тандан судлах, үр нөлөөг үнэлэх аргачлалыг боловсруулан мөрдөх; /2022-2023 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд үйлчилж буй эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлын календарчилсан төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх /2021-2024 он/;

- Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах /2021-2022 он/;

- Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах /2021-2022 он/;

- Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх /2021-2022 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх /2021-2024 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгж тухай бүр нийт алба хаагчийн оролцоотойгоор байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, эрх зүйн актуудыг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, дүгнэлт боловсруулах ажлыг хэвшүүлэх /2021-2024 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн үр дүнд үндэслэн, алба хаагчдын албан хэрэгцээнд ашиглах гарын авлага, заавар, зөвлөмж боловсруулах /2022-2023 он/;

4.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бодит хэрэгцээ, шаардлагад тулгуурлан эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх **гуравдугаар зорилтын хүрээнд:**

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх /2022-2023 он/;

- Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаа түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах /2021-2024 он/;

- Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах /2021-2024 он/;

- Захиргаа - удирдлага, сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг зохицуулсан эрх зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах /2021-2024 он/;

- Баривчлах үйл ажиллагаа болон баривчлах байрны эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх талаар эрх зүйн орчинг бий болгох /2021-2022 он/;

- Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих үйл ажиллагааны талаарх эрх зүйн зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд бие даасан бүлэг болгон оруулах хуулийн төслийг боловсруулж, удирдах байгууллагад уламжлах /2021-2022 он/;

- Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд бие даасан бүлэг болгон оруулах эрх зүйн орчинг судлан шийдвэрлэх /2021-2022 он/;

- “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгасан Батлан хамгаалах тухай хуульд заасан төрийн цэргийн байгуулалд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг хамааруулах хуулийн төслийг боловсруулан холбогдох байгууллагад уламжлах /2021-2022 он/;

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурлан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын жагсаалтад багтаах буюу Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хуулийн төслийг боловсруулж холбогдох байгууллагад уламжлах /2021-2022/;

- Алба хаагчдын эрх зүйн баталгааг хангах зорилгоор Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Цэргийн цол олгох журам, Цэргийн нийтлэг дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, удирдах байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх /2021-2022 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төрөл мэргэжлийн албан тушаалын гүйцэтгэх чиг үүргийн давхардлыг арилгах, эрх хэмжээ, үүрэг хариуцлагын талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох /2022-2023 он/;

4.4. Салбарын хэмжээнд үйлчилж буй эрх зүйн актуудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хууль тогтоомжийг чиглэл тус бүрээр төрөлжүүлэн нэгтгэх, нэгтгэн найруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх **дөрөвдүгээр зорилтын хүрээнд:**

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актуудыг системчлэх зорилго бүхий үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх; /2022-2023 он/;

- Хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр ижил төстэй харилцааг зохицуулж буй дүрэм, журам, зааврыг нэгтгэн найруулах /2021-2024 он/;

- Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй дүрэм, журам, зааврын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар нэгтгэн найруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх /2021-2024 он/;

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах зорилгоор төрөлжүүлэн нэгтгэх ажлыг зохион байгуулах /2022-2024 он/;

- Захиргаа, санхүү, хүний нөөц, хэвлэл мэдээллийн чиглэлээр мөрдөгдөж буй эрх зүйн актууд утга найруулгын хувьд ижил төсөөтэй байдлыг харгалзан нэгтгэн найруулах /2021-2022 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн хэрэглээнд зориулан захиргаа, хүний нөөц, сургалт, хэвлэл мэдээлэл, хорих ял, хорихоос өөр төрлийн ял, шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр төрөлжүүлэн хууль эрх зүйн актуудын гарын авлага болгон гаргах /2022-2023 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх, дотогш чиглэсэн эрх зүйн актуудыг бий болгон мөрдүүлэх, тэдгээрийг боловсронгуй болгон системчлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах /2021-2024 он/;

- Эрх зүйн актуудыг боловсронгуй болгон системчлэх асуудлыг иж бүрнээр судлан,

харьяа салбар нэгжээс ирсэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаарх саналуудыг нэгтгэн дүрэм, журам, заавруудыг үе шаттайгаар шинэчлэн найруулах; /2021-2024 он/;

4.5. Салбарын хэмжээнд хууль хэрэглээний соёлыг бэхжүүлэх сургалт, суртчилгаа, нөлөөллийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах **тавдугаар зорилтын хүрээнд:**

- Алба хаагчдын дунд хууль, эрх зүйн актуудын хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэх талаар хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг хэвшүүлэх /2021-2024 он/;

- Алба хаагчийн эрх зүйн боловсрол, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөр боловсруулж, үр дүнг тооцох /2022-2024 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хууль, тогтоомж түүний хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах /2021-2024 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа эрх зүйн баримт бичгүүдийг алба хаагчдын өдөр тутмын хэрэглээнд ашиглагдах цахим хувилбар /аплейкешн/-ыг боловсруулах /2022-2023 он/;

- Иргэд, олон нийтэд хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, албадлагын арга хэмжээ, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх орчинг бүрдүүлэх/2022-2023 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актуудын агуулга, ач холбогдол, онцлог, хэрэгжилтийн талаар дүрст болон аудио, контент, мэдээлэл бэлтгэн иргэд олон нийтэд хүргэх /2021-2024 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах хууль тогтоомжийн эмхэтгэл гаргаж хэрэглээнд оруулах /2021-2024 он/

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжийн хэрэглээний мэдлэг сорьсон “Хуулийг хэн сайн мэдэх вэ” дэвжээ тэмцээнийг тогтмол зохион байгуулах; /2021-2024 он/;

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох аргачлал, хууль зүйн тайлбар бүхий зурагт хуудас, цахим хичээлийг бэлтгэн алба хаагчдад хүргэх /2021-2024 он/;

Тав. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

5.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

5.1.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актуудыг тогтмол шинэчилж байх;

5.1.2. Шинэчлэн боловсруулж байгаа эрх зүйн актууд нь хууль тогтоомжид нийцсэн байх;

5.1.3. Эрх зүйн актуудад харьяа алба, газар, хэлтэс, хорих анги салбар нэгжээс ирүүлсэн саналыг тусгасан байх;

5.1.4. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийгдсэн байх;

5.1.5. Алба хаагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах орчинг бүрдүүлсэн байх;

5.1.6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх чиглэлээр хууль тогтоомжид өөрчлөлт орсон байх;

5.1.7. Алба хаагч хуулийг хэрэглэх ур чадварт суралцсан байх;

5.1.8. Иргэд болон нийт байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй авах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байх;

5.1.9. Хууль зүйн салбарын бусад байгууллагуудтай хамтран ажиллах ажиллагааг өргөжүүлж, туршлага солилцох ажлыг тогтмол зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байх;

Зургаа. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зорилт, үйл ажиллагааны үр дүнгээр үнэлэх бөгөөд жил бүр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулж болно.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг тухайн жилийн 12 дугаар сард Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

6.3. Төсөв, санхүүгийн дутагдал, удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалан дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, хязгаарлагдах нөхцөл үүсэж болно.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

7.1.1. Улсын төсөв;

7.1.2.Олон Улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын төсөл хөтөлбөр хандив, буцлалтгүй тусламж;

7.1.3.бусад эх үүсвэр;

Найм. Хөтөлбөрийн үр дүн

8.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

1 дүгээр зорилтын хүрээнд:

- Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр хийх эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажил тогтмолжсон байна.

- Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллага, их дээд сургуулиудтай судалгааны чиглэлээр хамтран ажиллах ажиллагаа өргөжсөн байна.

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр судалгааны ажил хийгдсэн байна.

- Гадаад орны хууль эрх зүйн орчинг харьцуулан судлах ажил тогтмол хийгддэг болсон байна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын байгууллагын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эрсдэлийг үнэлэх аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.

2 дугаар зорилтын хүрээнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажил тогтмолжсон байна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа алба, газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжүүд хууль, эрх зүйн актуудыг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, дүгнэлт боловсруулах ажил хэвшсэн байна.

- Хууль тогтоомжийн хэрэглээний талаарх гарын авлага, заавар, зөвлөмжийг боловсруулж алба хаагчдын өдөр тутмын хэрэглээнд нэвтрүүлсэн байна.

3 дугаар зорилтын хүрээнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “Хөгжлийн бодлогын баримт бичиг”-тэй болох эрх зүйн орчин бүрдсэн байна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт чиглэл тус бүрээр боловсронгуй болсон байна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал

дээшилсэн байна.

4 дүгээр зорилтын хүрээнд:

- Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актуудын давхардал, хийдэл, зөрчил арилсан байна.
- Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актууд боловсронгуй болсон байна.
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актуудын уялдаа холбоо сайжирсан байна.
- Захиргаа, санхүү, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр мөрдөгдөж буй эрх зүйн актууд боловсронгуй болсон байна.
- Салбарын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актуудын давхардал, хийдэл, зөрчил арилсан байна.

5 дугаар зорилтын хүрээнд:

- Алба хаагчдын дунд хууль, эрх зүйн актуудын хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэх талаарх хэлэлцүүлэг жил бүр тогтмол зохион байгуулагддаг болсон байна.
- Хэлэлцүүлгийн үр дүнд гарсан санал, дүгнэлтийг эрх зүйн шинэтгэлд тусгах ажлыг бодит үр дүнд хүргэсэн байна.
- Алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг чадвар дээшилж тодорхой үр дүнд хүрсэн байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол үр дүнтэй зохион байгуулдаг болсон байна.
- Алба хаагчдад эрх зүйн боловсрол олгох сургалтыг чиглэл тус бүрээр зохион байгуулах ажил хэвшсэн байна.

Ес. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

9.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавина.

9.2. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

9.3. Захиргааны удирдлагын газар хөтөлбөрийн явц, түүний биелэлтийг тухайн жилийн эцэст Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын зөвлөлийн

хуралдаанаар хэлэлцүүлж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг шийдвэрлүүлэн ажиллана.

9.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар, нэгжүүд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байна.

---o0o---



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 44 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (2021-2024 он)

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хариуцах нэгж |
|--|--|--------------|--|--|
| НЭГДҮГЭЭР ДҮГЭЭР ЗОРИЛТ: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэх; | | | | |
| 1 | Гадаадын зарим улс орны ижил чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг өөрийн орны хууль тогтоомжтой харьцуулан судлах; | 2021-2024 он | - Өөрийн орны хууль тогтоомжийг бусад орны хууль тогтоомжтой харьцуулан судалж боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулсан байна. - Гадаад орны хууль тогтоомжийг харьцуулан судлах ажил тогтмолжсон байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 2 | Дотоод хэргийн их сургуультай хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэрэгцээ шаардлагад тулгуурлан захиалгат судалгааны ажлыг гүйцэтгүүлэх; | 2021-2022 он | -Дотоод хэргийн их сургуультай хамтран зохион байгуулах сургалт, судалгааны хамтын ажиллагаа өргөжсөн байна. -Байгууллагын хэрэгцээ шаардлагад тулгуурлан захиалгат судалгааны ажлыг төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 3 | Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллага, их дээд сургуулиудтай хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажлыг хэрэгжүүлэх; | 2021-2024 он | - Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллага, их дээд сургуулиудтай хамтын ажиллагаа өргөжсөн байх; - ШШГБ-ын эрх зүйн орчинг боловсронгуй болгох сэдэвт эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажлыг бусад байгууллагуудтай хамтран тогтмол зохион байгуулдаг болсон байх; | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |

| | | | | |
|----|---|--------------|--|--|
| 4 | Хууль зүйн салбарын тэргүүлэх зэргийн эрдэмтэн, судлаачидтай хамтран эрүүгийн ялын бодлого, эрүү, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох суурь болон хавсарга судалгааны ажлыг гүйцэтгэх; | 2021-2022 он | - Хууль зүйн салбарын тэргүүлэх зэргийн эрдэмтэн, судлаачидтай хамтран судалгааны ажлыг хэрэгжүүлсэн байх; - Эрүү, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох суурь болон хавсарга судалгааны ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 5 | Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр судалгааны ажлыг өргөжүүлэх; | 2022-2023 он | - Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжсөн байх; | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 6 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх арга замыг тодорхойлох хавсарга судалгааны ажлыг хэрэгжүүлэх; | 2021-2024 он | - ШШГБ-ын алба хаагчийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх хавсарга судалгааны ажлыг хийгдсэн байна. - ШШГБ-ын алба хаагчийн эрх зүйн байдал дээшилсэн байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 7 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүргийн онцлогт тулгуурлан байгууллагын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсруулан үйл ажиллагаанд нэвтрүүлэх; | 2022-2023 он | - Байгууллагын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсруулан үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 8 | Эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулах замаар байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд тулгамдаж буй сорилт, бэрхшээлийг тодорхойлох; | 2021-2024 он | - Байгууллагын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулагдаж болсон байна. | ЗУГ, ХЯЭА, ХӨТЯЭА, ШГА |
| 9 | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын чиглэлээр доктор, магистрын түвшний судалгааны ажлын сэдвийг ажлын сэдэв, чиглэлийг тодорхойлох; | 2021-2022 он | - ШШГБ-ын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр доктор, магистрын түвшний судалгааны ажлын сэдвийг жагсаалтыг гарган батлуулсан байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 10 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны | 2022-2024 он | - Шүүхийн шийдвэр | гүйцэтгэх |

| | | | | |
|--|--|--------------|--|--|
| | чиглэлээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг практик үйл ажиллагаанд эргэлтэд оруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх; | | ажиллагааны чиглэлээр хийж гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг практик үйл ажиллагаанд эргэлтэд оруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна. | ЗҮГ, ХЯЭА, ХӨТЯЭА, ШГА |
| ХОЁРДУГААР ЗОРИЛТ: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлыг тогтмолжуулах; | | | | |
| 11 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, харьяа салбар нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлыг тусган хэрэгжилтийг хангах; | 2021-2024 он | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, харьяа салбар нэгжүүд хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлыг үйл ажиллагаандаа хэвшүүлсэн байна. | Захиргааны удирдлагын газар, Харьяа алба, газар, хэлтэс, хорих анги, салбар нэгж |
| 12 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм, журмыг шинээр боловсруулах, хэрэгцээ шаардлагыг тандан судлах, үр нөлөөг үнэлэх аргачлалыг боловсруулан мөрдөх; | 2022-2023 он | - Шинэчлэн боловсруулах дүрэм, журам, зааврын жагсаалтыг гарган батлуулсан байх. - Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагыг тандан судлах, үр нөлөөг үнэлэх аргачлалыг боловсруулан үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна. | Захиргааны удирдлагын газар, Харьяа алба, газар, хэлтэс, хорих анги, салбар нэгж |
| 13 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд үйлчилж буй эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлын календарчилсан төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх; | 2021-2024 он | - ШШГБ-ын хэмжээнд үйлчилж буй эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх календарчилсан төлөвлөгөөг гаргасан байх. - Эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийх ажил тогтмолжсон байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс |
| 14 | Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах; | 2021-2022 он | - Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил арилсан байна. | Захиргааны удирдлагын газар, Хорих ял эдлүүлэх алба |

| | | | | |
|----|--|--------------|---|--|
| 15 | Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах; | 2021-2022 он | - Эрх зүйн актад дүн шинжилгээ хийх ажил тогтмолжсон байна. - Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй эрх зүйн актуудын давхардал, хийдэл, зөрчил арилж боловсронгуй болсон байна. - Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажил тогтмолжсон байна. - Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил арилсан байна. | Захиргааны удирдлагын газар, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба |
| 16 | Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх; | 2021-2022 он | - Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчил арилсан байна. | Захиргааны удирдлагын газар, Шийдвэр гүйцэтгэх алба |
| 17 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдлыг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх; | 2021-2024 он | - Алба хаагчийн эрх зүйн байдлыг зохицуулж буй хууль тогтоомж боловсронгуй болсон байна. - Хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх ажил тогтмолжсон байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 18 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгж тухай бүр нийт алба хаагчийн оролцоотойгоор байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй хууль, эрх зүйн актуудыг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, дүгнэлт боловсруулах ажлыг хэвшүүлэх; | 2021-2024 он | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа алба, газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжүүдийн хууль, эрх зүйн актуудыг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, дүгнэлт боловсруулах ажил тогтмолжсон байна. | Захиргааны удирдлагын газар, Харьяа алба, газар, хэлтэс, хорих анги, салбар нэгж |
| 19 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн үр дүнд үндэслэн, алба хаагчдын албан хэрэгцээнд ашиглах гарын авлага, заавар, зөвлөмж боловсруулах; | 2022-2023 он | - Албан хэрэгцээний хууль эрх зүйн гарын авлагатай болсон байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |

ГУРАВДУГААР ЗОРИЛТ: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бодит хэрэгцээ, шаардлагад тулгуурлан эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх

| | | | | |
|----|---|--------------|---|--|
| 20 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх; | 2022-2023 он | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага урт, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах хууль эрх зүйн орчин бүрдсэн байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, Дотоод ажлын хэлтэс |
| 21 | Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаа түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах; | 2021-2024 он | - Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг урьдчилан судалсан байна. - Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт боловсронгуй болсон байна. | Захиргааны удирдлагын газар, Хорих ял эдлүүлэх алба |
| 22 | Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах; | 2021-2024 он | - Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт боловсронгуй болсон байна. | Захиргааны удирдлагын газар, Шийдвэр гүйцэтгэх алба |
| 23 | Захиргаа - удирдлага, сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн боловсронгуй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах; | 2021-2024 он | - Захиргаа - удирдлага, сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн боловсронгуй болж давхардал, хийдэл, зөрчил арилсан байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, Дотоод ажлын хэлтэс |
| 24 | Баривчлах үйл ажиллагаа болон баривчлах байрны эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх талаар эрх зүйн орчинг бий болгох; | 2021-2022 он | - Баривчлах байрны эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх талаарх зохицуулалтыг Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, удирдах байгууллагад хүргүүлсэн байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, Дотоод ажлын хэлтэс |
| 25 | Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих үйл ажиллагааны талаарх эрх зүйн зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд бие даасан бүлэг болгон оруулах хуулийн төслийг боловсруулж, удирдах байгууллагад | 2021-2022 он | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг бие даасан бүлэг болгон оруулах хуулийн төслийг боловсруулж, | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, Дотоод ажлын хэлтэс |

| | | | | |
|----|---|--------------|--|--|
| 26 | уламжлах; Согтуурах, мансуурах донтой захиргааны журмаар албадан эмчлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд бие даасан бүлэг болгон оруулах эрх зүйн орчинг судлан шийдвэрлэх; | 2021-2022 он | удирдах байгууллагад хүргүүлсэн байна. - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг бие даасан бүлэг болгон оруулах талаар эрх зүйн орчинг судалж, удирдах байгууллагаар шийдвэрлүүлсэн байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 27 | "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д тусгасан Батлан хамгаалах тухай хуульд заасан төрийн цэргийн байгуулалд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг хамааруулах хуулийн төслийг боловсруулан холбогдох байгууллагад уламжлах; | 2021-2022 он | - Батлан хамгаалах тухай хуульд заасан төрийн цэргийн байгуулалд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг хамааруулах хуулийн төслийг боловсруулан холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлсэн байна; | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 28 | Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурлан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын жагсаалтад багтаах буюу Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хуулийн төслийг боловсруулж холбогдох байгууллагад уламжлах; | 2021-2022 он | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын жагсаалтад багтаах буюу Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хуулийн төслийг боловсруулж холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлсэн байна; | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 29 | Алба хаагчдын эрх зүйн баталгааг хангах зорилгоор Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Цэргийн цол олгох журам, Цэргийн нийтлэг дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, удирдах байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх; | 2021-2022 он | - Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн цол олгох журам, Цэргийн нийтлэг дүрмүүдэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг тусгах нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, удирдах байгууллагад уламжлан шийдвэрлүүлсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |

| | | | | |
|---|---|--------------|---|--|
| 30 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төрөл мэргэжлийн албан тушаалын гүйцэтгэх чиг үүргийн давхардлыг арилгах, эрх хэмжээ, үүрэг хариуцлагын талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох; | 2021-2022 он | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төрөл мэргэжлийн албан тушаалын гүйцэтгэх чиг үүргийн давхардал арилж, эрх хэмжээ, үүрэг хариуцлагын талаарх эрх зүйн зохицуулалт боловсронгуй болсон байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| Дөрөвдүгээр зорилт: Салбарын хэмжээнд үйлчилж буй эрх зүйн актуудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хууль тогтоомжийг чиглэл тус бүрээр төрөлжүүлэн нэгтгэх, нэгтгэн найруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх | | | | |
| 31 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актуудыг системчлэх зорилго бүхий үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх; | 2022-2023 он | - Эрх зүйн актуудыг системчлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 32 | Хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр ижил төстэй харилцааг зохицуулж буй дүрэм, журам, зааврыг нэгтгэн найруулах; | 2021-2024 он | - Хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр ижил төстэй харилцааг зохицуулж буй дүрэм, журам, зааврыг нэгтгэн найруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулсан байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 33 | Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй дүрэм, журам, зааврын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар нэгтгэн найруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх; | 2021-2024 он | - Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй дүрэм, журам, зааврын давхардал, хийдэл, зөрчил арилж боловсронгуй болсон байна. | Захиргааны удирдлагын газар, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба |
| 34 | Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах зорилгоор төрөлжүүлэн нэгтгэх ажлыг зохион байгуулах; | 2021-2024 он | - Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг төрөлжүүлэн нэгтгэх ажлыг зохион үр дүнтэй зохион байгуулсан байна. | Захиргааны удирдлагын газар, Шийдвэр гүйцэтгэх алба |
| 35 | Захиргаа, санхүү, хүний нөөц, хэвлэл мэдээллийн чиглэлээр мөрдөгдөж буй эрх зүйн актууд утга найруулгын хувьд ижил төсөөтэй байдлыг харгалзан нэгтгэн найруулах; | 2021-2022 он | - Захиргаа, санхүү, хүний нөөц, хэвлэл мэдээллийн чиглэлээр мөрдөгдөж буй эрх зүйн актууд боловсронгуй болсон байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |

| | | | | |
|--|---|--------------|--|--|
| 36 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба хаагчийн хэрэглээнд зориулан захиргаа, хүний нөөц, сургалт, хэвлэл мэдээлэл, хорих ял, хорихоос өөр төрлийн ял, шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр төрөлжүүлэн хууль эрх зүйн актуудын гарын авлага болгон гаргах; | 2022-2023 он | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэл тус бүрээр эрх зүйн актуудын гарын авлагатай болсон байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 37 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх, дотогш чиглэсэн эрх зүйн актуудыг бий болгон мөрдүүлэх, тэдгээрийг боловсронгуй болгон системчлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах; | 2021-2024 он | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актууд боловсронгуй болсон байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| 38 | Эрх зүйн актуудыг боловсронгуй болгон системчлэх асуудлыг иж бүрнээр судлан, харьяа салбар нэгжээс ирсэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаарх саналуудыг нэгтгэн дүрэм, журам, заавруудыг үе шаттайгаар шинэчлэн найруулах; | 2021-2024 он | - Эрх зүйн актуудыг боловсронгуй болгон системчлэх асуудлыг иж бүрнээр судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна. - Дүрэм, журам, заавруудыг шинэчлэн боловсруулах төлөвлөгөө гарган батлуулсан байх. - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актууд боловсронгуй болсон байна. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтэс |
| ТАВДУГААР ЗОРИЛТ: САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ СОЁЛЫГ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТ, СУРТЧИЛГАА, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ | | | | |
| 39 | Алба хаагчдын дунд хууль, эрх зүйн актуудын хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэх талаар хэлэлцүүлэг зохион байгуулах ажлыг хэвшүүлэх; | 2021-2024 он | - Эрх зүйн актуудын хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэх хэлэлцүүлэг зохион байгуулах төлөвлөгөөг гарган батлуулсан байх. - Хэлэлцүүлгийг үр дүнд алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн байна. | Захиргааны удирдлагын газар, Харьяа алба, газар, хэлтэс, хорих анги, салбар нэгж |
| 40 | Алба хаагчийн эрх зүйн боловсрол, мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөр боловсруулж, үр дүнг тооцох; | 2022-2024 он | - Алба хаагчийн эрх зүйн боловсрол, мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлсэн байна. - Алба хаагчийн эрх зүйн боловсрол, хорих анги, салбар | Захиргааны удирдлагын газар, Харьяа алба, газар, хэлтэс, хорих анги, салбар |

| | | | | нэгж |
|----|---|--------------|---|--|
| 41 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хууль, тогтоомж түүний хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах; | 2021-2024 он | мэдлэг, үр чадвар дээшилсэн байна. - Хууль, тогтоомж түүний хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна. - Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөө дээшилсэн байна. - Хууль, тогтоомж түүний хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх сургалтын ажил тогтмолжсон байна. | Захиргааны удирдлагын газар, Харьяа алба, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгж |
| 42 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа эрх зүйн баримт бичгүүдийг алба хаагчдын өдөр тутмын хэрэглээнд ашиглагдах цахим хувилбар /аплейкешн/-ыг боловсруулах; | 2022-2023 он | - Алба хаагчдын өдөр тутмын хэрэглээнд зориулсан хууль эрх зүйн нэгдсэн сан бүхий гар утасны /аплейкешн/-г бүтээж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Мэдээлэл технологийн хэлтэс |
| 43 | Иргэд, олон нийтэд хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, албадлагын арга хэмжээ, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, тусалцаа үзүүлэх орчинг бүрдүүлэх; | 2022-2023 он | - Иргэд, олон нийтэд Хорих ял, Хорихоос өөр төрлийн ял болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, тусалцаа өгөх нээлттэй угсыг ашиглалтад оруулсан байх. | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, Дотоод ажлын хэлтэс |
| 44 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актуудын агуулга, ач холбогдол, онцлог, хэрэгжилтийн талаар дүрст болон аудио, контент, мэдээлэл бэлтгэн иргэд олон нийтэд хүргэх; | 2021-2024 он | - Иргэд олон нийт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон даган гарсан эрх зүйн актуудын агуулга, ач холбогдол, онцлогын талаар ойлголттой болсон байна. - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон бусад эрх зүйн актуудын агуулга, онцлогыг тусгасан контент бэлтгэн иргэд олон нийтэд хүргэсэн байх; | Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв, Мэдээлэл технологийн хэлтэс |
| 45 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах хууль тогтоомжийн эмхэтгэл гаргаж хэрэглээнд оруулах; | 2021-2024 он | - Алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд зориулагдсан эрх зүйн актын эмхэтгэл боловсруулагдан гарсан байх; | Захиргааны удирдлагын газар, Хууль тогтоомж, Дотоод ажлын хэлтэс |
| 46 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэг, | 2021-2024 он | - Алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэг, боловсрол дээшилсэн байна. | Захиргааны удирдлагын газар, |

| | | | | |
|-----------|---|---------------------|---|--|
| | <p>боловсролыг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжийн хэрэглээний мэдлэг сорьсон “Хуулийг хэн сайн мэдэх вэ” дэвжээ тэмцээнийг тогтмол зохион байгуулах;</p> | | <p>- “Хуулийг хэн сайн мэдэх вэ” дэвжээ тэмцээн жил бүр тогтмол зохион байгуулагдадаг болсон байна.</p> | <p>Харьяа алба, газар, хэлтэс, хорих анги, салбар нэгж</p> |
| <p>47</p> | <p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох аргачлал, хууль зүйн тайлбар бүхий зурагт хуудас, цахим хичээлийг бэлтгэн алба хаагчдад хүргэх;</p> | <p>2021-2024 он</p> | <p>- Алба хаагчид эрх зүйн орчинг боловсронгуй болгох аргачлалд суралцсан байх; - Хууль, дүрэм, журам, зааврын хэрэглээний талаар тайлбарласан зурагт хуудсыг боловсруулж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байх; - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар цахим хичээлийг боловсруулж алба хаагчдын суралтад ашиглаж эхэлсэн байх.</p> | <p>Захиргааны удирдлагын газар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв</p> |

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР